



## “МОНГОЛ БАЗАЛЬТ” ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ

### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар “Монгол Базальт” ХК-ийн хөрөнгө оруулагчдад ашиг хуваарилах ногдол ашгийн бодлого, ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү ногдол ашгийн журмыг компанийн ТУЗ-өөс боловсруулан батлаж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглана.
- 1.3. Энэхүү журам нь хувьцаа эзэмшигчид болон ирээдүйн хөрөнгө оруулагчдад компанийн ашиг хуваарилалтын бодлого, хэмжээ, хуваарилах арга хэлбэрийн талаар тодорхой нэгдсэн ойлголтыг хүргэнэ.

### Хоёр. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- 2.1. Компани нь хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах зорилготой ажиллана.
- 2.2. Компанийн ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн батлана.
- 2.3. Компани тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилаж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөгөө танилцуулна.
- 2.4. Компанийн үйл ажиллагааны ашгаас хөрөнгө оруулагчдад ногдол ашиг хуваарилахдаа ногдол ашгийг бэлэн мөнгө, үнэт цаас, биет эд хөрөнгөөр олгож болно.

### Гурав. АШГИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ

- 3.1. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг болдог учраас энэ шийдвэр нь компанийн бодит байдлыг зөв тусгасан үзүүлэлт байна.
- 3.2. Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байна. Энэхүү дүн нь компанийн тухайн жилийн цэвэр ашгийн 20%-иас доошгүй хэмжээтэйгээр хуваарилаж болно.

Бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр ногдол ашиг тараах тохиолдолд тухайн эд хөрөнгө, үнэт цаасны үнэлгээг ТУЗ-өөс тогтооно.

#### **Дөрөв. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ**

- 4.1. Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох цаг хугацаа нь компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- 4.2. Компани хувьцаа эзэмшигчиддээ бэлэн мөнгөөр ногдол ашиг хуваарилахдаа хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансаар дамжуулан нэгдсэн журмаар олгоно.
- 4.3. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацааг тодорхой зааж, тогтоосон хугацаандаа бүрэн олгож дуусна.

#### **Тав. МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ**

- 5.1. Тухайн жил тараасан ногдол ашгийн хэмжээ болон тараах журмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар мэдэгдэн, компанийн веб хуудсаар дамжуулан нийтийн хүртээл болгохоос гадна ТУЗ-ийн нарийн бичгээр дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.